

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт

НЭГДСЭН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
НЭРГҮЙН ЗОЛЖАРГАЛЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт						
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа
	1	2	3	4	5	6
	Зорилт 1: "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих урт, дунд, хугацааны бодлого, стратеги, хөтөлбөрийн чиглэлийг тодорхойлох, бодлого хөтөлбөрийн үр нөлөөг үнэлэх, үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг боловсруулах, төлөвлөх зорилтын хүрээнд"					7
1.	Арга хэмжээ 1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, чиглэлийг тодорхойлох, Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах бодлого, арга хэмжээг төлөвлөх, санал боловсруулах	Саналын тоо	-	1	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөлд холбогдох 3 хүснэгтийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, чиглэлийг тодорхойлох, үйл ажиллагаанд тусгах саналыг нэгтгэн боловсруулж, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар хариуцан хэрэгжүүлэх 57 зорилтын 105 арга хэмжээний хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 15 зорилтын 31 арга хэмжээний саналыг тусгасан байна. Мөн ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг хөдөлмөрийн бодлогын газартай	2025.01.02-2025.06.30

					хамтран боловсруулж саналыг тусгасан болно.	
					Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэл, мөн 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэл, Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооны 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан, бүсийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх олон талт арга хэмжээ зохион байгуулахаар шийдвэрлэсэн.	
					Дээрх тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулалтыг ханган ажиллах чиг үүрэг бүхий ГБНХС-ын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/45 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг ажиллаж байна. Тус ажлын хэсэг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Хангайн бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан Архангай аймагт зохион байгууллаа.	
					Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” албан даалгаврын 4.2.1-д заасны дагуу тус салбараас бүсчилсэн хөглийн бодлоготой уялдуулан, бүс, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх төслийн саналыг гарган хүргүүлсэн.	
					Мөн Хангайн бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын	

				Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлт, бизнес аж ахуй эрхлэлтийг дэмжих, гарааны болон бичил, жижиг бизнесийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн орчныг сайжруулах, хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилтуудын хэрэгжилтийг хангах зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран зорилтот бүлгийн иргэний үүсгэн байгуулсан болон Хангайн бүсийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг бичил, жижиг аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих тогтолцоог бүрдүүлэх зорилгоор “Хөгжлийн гүүр” туршилтын төслийг танилцуулсан болно. Тус хуралдааны хүрээнд Засгийн газрын 181, 182 дугаар тогтоол гарсан. 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн ТНБД-ын А/130 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг Хойд бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Булган аймагт ажиллалаа. Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар ГБХНХ-ын сайд Хойд бүсийн хөгжил-2040 салбар хуралдаанд панелистаар оролцож Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний талаар хэлэлцсэн. Тус хуралдаантай холбогдуулан Засгийн газрын 2025 оны 20 дугаар хуралдааны
--	--	--	--	---

					тэмдэглэл, Засгийн газрын 204, 209 дүгээр тогтоол гарсан. 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн ТНБД-ын А/147 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг Говийн бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Дорноговь аймагт ажиллалаа. Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар ГБХНХ-ын сайд, ажлын хэсгийн бүрэлдэхүүн Говийн бүсийн хөгжил-2040 салбар хуралдаанд оролцсон. Тус хуралдаанаар Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зарим арга хэмжээний талаар хэлэлцэж, Засгийн газрын 2025 оны 22 дугаар хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын 235 дугаар тогтоол гарсан. Төвийн болон бусад бүсүүдэд зохион байгуулагдах Засгийн газрын өргөтгөсөн хуралдаан цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон болно.	
Зорилт 2. “ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, САЛБАР ДУНДЫН ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД”						
Арга хэмжээ 2.1. Бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, практикийг судалж, тэдгээрийг шинэчлэх үндэслэл, хэрэгцээг тодорхойлж, боловсронгуй болгох санал боловсруулах	Ажлын хэсэг Санал-1	-	1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын тогтолцоонд дүн шижилгээ хийх, системийн инженерчлэлийн аргаар тогтолцооны бүтцэд оруулах, уг тогтолцоог бүрдүүлэхэд шаардлагатай шийдлүүдийг хөгжүүлэх, нэвтрүүлэх замаар Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар заалтаар баталгаажсан иргэдийн нийгмийн баталгааг хангах үндэсний тогтолцоог төгөлдөржүүлэх, загвар	2025.01.02-2025.06.30	

				боловсруулах судалгааны багийн ажлын хэсгийг ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/54 тоот тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нийт 23 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, салбарт хэрэглэгддэг гол ойголт, "Тус томьёоны тулгуур ойлголтыг "Тус солюшн" ХХК-аас гаргасан аргачлал, загварын дагуу тодорхойлж, Монгол Улсын Үндсэн хууль, Алсын хараа 2050, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Олон улсын баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын тогтолцоонд бүрдүүлэх ёстой хэв шинжүүдээр задлах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Судалгааны багийн ажлын нэгдсэн тайланг 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Төрийн ордны Жанжин Сүхбаатар танхимд Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд, холбогдох яамдын төлөөлөл, мэргэжлийн зөвлөл, хороод болон салбарын судлаач, эрдэмтдийн төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтэд нээлттэй танилцуулга хүргэж, уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.					Азийн бүтээмжийн байгууллага, Монголын бүтээмжийн холбоотой хамтран үндэсний бүтээмжийн үзэл баримтлалыг тодорхойлж, үндэсний хэмжээнд бүтээмжийн хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилго бүхий	2025.01.02- 2025.06.30	
--	--	--	--	---	--	--	--	--	---	-----------------------------------	--

					БҮТЭЭМЖИЙН ХУВЬСАЛ чуулганыг зохион байгуулсан. Монгол Улсын хөдөлмөрийн дундаж бүтээмж дэлхийн дунджаас 3.6 дахин, БНСУ-аас 5.4 дахин бага байна. Хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлстэй шууд хамааралтай юм. Манай улсад уул уурхай, мэдээлэл технологийн салбар хамгийн их бүтээмжтэй, цалин өндөр байна. Иймээс хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүх түвшинд баримталсан зохистой ажлын байрыг бий болгож, бүтээмжийн экосистемийг бий болгох, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг хэрэгжүүлэн, бүтээмжийн үндэсний мастер төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна. Энэ хүрээнд Азийн бүтээмжийн байгууллага, Монголын бүтээмжийн төв ТББ-ын төлөөлөл, Үндэсний статистикийн хороо, ХНХСҮСИ, ММСГ ХХК-ийн судалгааны багийн төлөөлөл болон яамны холбогдох газар, хэлтсийн мэргэжилтнүүдийг оролцуулан уулзалт хэлэлцүүлгийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр, 06 дугаар сарын 16-ны өдөр танхим болон цахим уулзалтыг тус тус зохион байгуулж, санал солилцлоо. Мөн төрийн болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодтой хамтарсан уулзалт хэлэлцүүлгийг 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж, оролцогч талуудаас гаргасан санал дүгнэлт, зөвлөмжид үндэслэн Бүтээмжийн үндэсний мастер төлөвлөгөөний төслийг 2025 оны 3 дугаар
--	--	--	--	--	--

						улиралд багтаан боловсруулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.	
Зорилт 4. “ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН ОНЦЛОГТ НИЙЦҮҮЛЭН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХЭД ЧИГЛЭСЭН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ХОЛБОГДОХ СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙГ СУДЛАН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ШИНЭЧЛЭХ ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ, САНАЛ БОЛОВСРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД”							
1.	Арга хэмжээ 4.1. Хөдөлмөр эрхлэлтийн талаар олон улсын туршлага, хууль эрх зүйн орчин, холбогдох тайлан, мэдээ, дүн шинжилгээ, үндэсний болон олон улсын байгууллагын судалгаа, статистик, тоон мэдээллийг судлах, харьцуулалт, дүгнэлт танилцуулга хийж, мэдээллээр хангах, хууль тогтоомжийг шинэчлэх үндэслэл, хэрэгцээг тодорхойлж санал боловсруулна.	Арга хэмжээний саналын тоо	-	1		Монгол Улсын Их Хурлаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”-г 2001 онд баталж, 2011 онд шинэчлэн найруулсан. Тус яамнаас “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”-г хууль эрх зүйн болон практик хэрэгцээ шаардлагын улмаас шинэчлэн найруулахаар төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Тус ажлын хэсэг хэд хэдэн удаагийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж төрийн болон төрийн бус байгууллага, оролцогч талуудаас санал, дүгнэлт авч нэгтгэн боловсруулж ХЭДТХ-ийн төслийн үзэл баримтлалыг ХЗДХЯ-нд батлуулсан. Энэ хүрээнд УИХ-д өргөн мэдүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна. Монгол улс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг хэрэгжүүлдэг. Жил бүр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа /төсөл, хөтөлбөр/-г шинэчлэн сайжруулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлж хэрэгжүүлдэг. Үүнтэй холбогдуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа /хөтөлбөр/-ийн зарцуулалт, үр дүнг тооцох, тайлангийн маягтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд	2025.01.02-2025.06.30

						саналаа тусган, хөдөлмөр эрхлэлтийн цахим систем "ejob" платформд нэмэлт хөгжүүлэлт хийхээр төлөвлөн ажиллаж байна.		
Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт								
Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
1.	Нийгмийн хамгааллын үндэсний концепци загвар боловсруулах ажлын тайланд "Зохистой Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоо, зорилго, зарчим, төрөлжсөн хэв шинжүүд" хэсгийг боловсруулах			Мэдээлэл бэлтгэсэн байна.	Нийгмийн хамгааллын үндэсний тогтолцооны концепци загвар боловсруулах ажлын тайланд "Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоо, түүний зорилго, зарчим, төрөлжсөн хэв шинжүүд" хэсгийг боловсруулав.	2025.01.27		
2.	"Хөдөлмөр дэмжих эрхлэлтийг сангийн хөдөлмөр зарцуулалтын үзүүлэх нөлөөллийн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсэг"-т ажиллах			Ажлын хэсэгт орж ажилласан байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/173 тоот тушаалаар байгуулсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалтын хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөөллийн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсэг"-т орж ажиллаж байна. Тус ажлын хэсэг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр хуралдаж - ХЭДС-ийн төлөвлөлт, зарцуулалт, төсвийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, - Чанарын үзүүлэлтийг оновчтой тодорхойлох - Анхан шатны нэгжээс асуулга авах	2025.05.26		

					Санал зөвлөмж гаргаж 2 дугаар улиралд багтаан ГБХНХ-ын сайдад танилцуулахаар болсон.		
3.	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар "Үндэсний их баяр наадам, Ардын наадам, Ардын хувьсгалын ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд ажил, амралтын цагийн зохицуулалтыг тусгах засгийн газрын тогтоолын төсөлд холбогдох тооцоо, мэдээллийг бэлтгэн боловсруулав.	Мэдээлэл бэлтгэсэн байна.			Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар "Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд ажил, амралтын цагийн зохицуулалтыг тусгах засгийн газрын тогтоолын төсөлд холбогдох тооцоо, мэдээллийг бэлтгэн боловсруулав.	2025.05.08	
4.	"Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга хэсэгт хөдөлмөр эрхлэлтийн тайлан бэлтгэх	Мэдээ, тайлан бэлтгэсэн байна.			"Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 9 зорилго, 73 шалгуур үзүүлэлтээс ГБХНХЯ-ны эрхлэх асуудалд хамаарах 2 зорилгын 51 үйл ажиллагаа, 1 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, гол ахиц, үр дүн, анхаарах асуудлыг 2020-2025 оноор гарган, мэдээлэл бэлтгэн хүргүүлэв. Энэ хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн статистик тоо мэдээллийг нэмэлтээр гарган хүргүүлэв.	2025.05.28	
5.	Үндэсний хорооноос "Зохистой хөдөлмөрийн статистик үзүүлэлтүүдийг тооцох гарын авлага"-д боловсруулах	Санал боловсруулж хүргүүлсэн байна.			Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргадаг "Зохистой хөдөлмөрийн статистик үзүүлэлтүүдийг тооцох гарын авлага"-ын төсөлд ГБХНХЯ-ны холбогдох газруудаас санал авч нэгтгэн ҮСХ-д хүргүүлсэн. Үүнтэй холбогдуулан гарын авлагын төсөлд өгсөн саналуудыг /тусгах боломжтойг/ эцэслэхээр 2 удаагийн	2025.01.17 - 2025.06.06	

					уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж санал, дүгнэлтээ хэлэлцсэн. Үний үр дүнд Үндэсний статистикийн хорооноос “Зохистой хөдөлмөрийн статистик үзүүлэлтүүдийг тооцох гарын авлага”-ыг эцэслэн боловсруулж, цахим хэлбэрээр 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр ирүүлсэн болно.		
6.	Нийгмийн хамгааллын үндэсний тогтолцооны загвар боловсруулах ажлыг баримтлалыг танилцуулах хэлэлцүүлэг байгуулах	Хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.			Нийгмийн хамгааллын үндэсний тогтолцооны загвар боловсруулах ажлыг Залуу судлаачдыг дэмжих сан ТББ-тай хамтран гүйцэтгэсэн. Дээрх ажлын хүрээнд Монгол Улсын нийгмийн хамгааллын тогтолцоо, салбарын үйл ажиллагааг зохицуулж байгаа 100 орчим эрхзүйн актад нэг бүрчлэн шинжилгээ хийж, СИСТЕМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН аргаар үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж гаргасныг 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Төрийн ордны Жанжин Сүхбаатар танхимд Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд, холбогдох яамдын төлөөлөл, мэргэжлийн зөвлөл, хороод болон салбарын судлаач, эрдэмтдийн төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтэд нээлттэй танилцуулга хүргэж, уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр: ◆Монгол Улсын хүн төвтэй, тогтвортой хөгжлийн эрхэм зорилго нь нийгмийн хамгааллын тогтолцоо юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын иргэн бүрэлдэн бий болохоос насан эцэслэх хүртэл нийгмийн цогц үйлчилгээгээр хамгаалагдах эрхтэй.	2025.06.13	

					◆Салбар бүр сайн боловсруулсан, чамбай хуультай ч, хэрэгжилт хангалтгүй байгаагийн шалтгаан нь амьдрал дээр хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, хэрэгжүүлэх, үүрэг хүлээх эзэн, хугацаа тодорхойгүйгээс үүдэн саатдаг нийтлэг бэрхшээлийг цаашид засаж сайжруулах, бүхий л түвшинд хамтран ажиллах, төр хувийн хэвшлийн түншлэлийг төрийн идэвхтэй бодлогоор өргөжүүлэх талаар санал дүгнэлт авч хэлэлцлээ. Мөн системийн шинжээчдийн өгсөн зөвлөмжид үндэслэн салбарын 7 хуулийн төслийг УИХ-д өргөн барихад бэлэн болголоо. Үүнд: ✓Гэр бүлийг дэмжих АНХДАГЧ хуулийн төсөл ✓Хувийн нэмэлт тэтгэврийн даатгалын тухай АНХДАГЧ хуулийн төсөл ✓Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ✓Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга ✓Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ✓Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулга ✓Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулга Эдгээр хуулийг баталснаар нийгмийн халамж зорилтот бүлэгтээ хүрсэн ОНОВЧТОЙ, Төр хувийн хэвшил, орон нутгийн хамтын ажиллагаатайгаар
--	--	--	--	--	--

						зорилтот өрх, иргэний бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжиж ХАЛАМЖААС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД шилжих зорилгыг хэрэгжүүлэх, Халамжийн төсвийн санхүүжилт ҮР АШИГ, ҮР НӨЛӨӨ дээшилнэ. Мөн Нийгмийн халамжийн хэрэгжилт сайжирч, төсвийн зарцуулалт нээлттэй, ил тод болж, ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, үнэлгээний тогтолцоо бүрдэх юм.		
7.	ГБХНХ-ын салбарын үндсэн үзүүлэлтэд Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийг 2020-2024 он, 2025 оны I улирлын байдлаар бэлтгэх				Мэдээлэл хүргүүлсэн байна	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын үндсэн үзүүлэлтэд Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийг 2020-2024 он, 2025 оны I улирлын байдлаар бэлтгэн боловсруулав.	2025.05.16	
8.	ҮСХ-оос ААНБ-ын тооллогыг 5 жил тутам зохион байгуулах ажлын хүрээнд ГБХНХЯ болон харьяа агентлагуудын МТТ-ийн болон бодлогын газрын мэргэжилтнүүдтэй уулзах уулзалтыг зохион байгуулж, санал солилцов.				Хулар зохион байгуулсан байна	ҮСХ-оос ААНБ-ын тооллогыг 5 жил тутам зохион байгуулах ажлын хүрээнд ГБХНХЯ болон харьяа агентлагуудын МТТ-ийн болон бодлогын газрын мэргэжилтнүүдтэй уулзах уулзалтыг зохион байгуулж, санал солилцов.	2025.06.17	

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Биелэлтийн хувь	
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)				Эхэлсэн, дууссан хугацаа
					1	2	3		
	1	2	3	4	5	6	7		

1.	Мэдлэг, боловсролоо дээшлүүлэх болон мэргэшүүлэх сургалтад хамрагдах.	Гадаад болон дотоодын сургалтад хамрагдсан сургалтын тоо	1-ээс дээш сургалт, семинарт хамрагдах.	Монгол бичгийн 8 удаагийн сургалтад хамрагдсан.	2025.05.13 - 2025.06.05	
----	---	--	---	---	-------------------------------	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хөдөлмөр эрхлэлтийн бодлого
төлөвлөлт хариуцсан ахлах
мэргэжилтэн
(Албан тушаал)

Н.Золжаргал /  /

(Нэр, гарын үсэг)

2025.06.06
.....

(Огноо)

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН НЭРГҮЙН ЗОЛЖАРГАЛЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нэгжийн нэр: Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгааж уулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих урт, дунд, хугацааны бодлого, стратеги, хөтөлбөрийн чиглэлийг тодорхойлох, бодлого хөтөлбөрийн үр нөлөөг үнэлэх, үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг боловсруулах, төлөвлөх”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, чиглэлийг тодорхойлох, Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах бодлого, арга хэмжээг төлөвлөх, санал боловсруулна.	55	10	65	65
2.	Арга хэмжээ 1.2. “Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан”-ы хүрээнд “Ажиллах хүчний бүтээмж, нийгмийн хамгаалал”-ын салбар хуралдааныг бүс бүрд зохион байгуулна.	60	10	70	70
Зорилт 2. “Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, салбар дундын зохицуулалтыг сайжруулах”-ыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 2.1. Бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, практикийг судалж, тэдгээрийг шинэчлэх үндэслэл, хэрэгцээг тодорхойлж, боловсронгуй болгох санал боловсруулна.	55	5	60	60
2.	Арга хэмжээ 2.2. Бүтээмжийн үндэсний мастер төлөвлөгөөний төслийг боловсруулна.	40	10	50	50

Зорилт 4. “Хүн амын бүлгүүдийн онцлогт нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн олон улсын туршлага, холбогдох судалгаа, мэдээллийг судлан хууль тогтоомжийг шинэчлэх үндэслэл, хэрэгцээг тодорхойлох, санал боловсруулах”-ыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

1.	Арга хэмжээ 4.1. Хөдөлмөр эрхлэлтийн талаар олон улсын туршлага, хууль эрх зүйн орчин, холбогдох тайлан, мэдээ, дүн шинжилгээ, үндэсний болон олон улсын байгууллагын судалгаа, статистик, тоон мэдээллийг судлах, харьцуулалт, дүгнэлт танилцуулга хийж, мэдээллээр хангах, хууль тогтоомжийг шинэчлэх үндэслэл, хэрэгцээг тодорхойлж санал боловсруулах	60	10	70	70
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалтын хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөөллийн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсэг"-т ажиллах	60	10	70	70
2.	Нийгмийн хамгааллын үндэсний тогтолцооны концепци загвар боловсруулах ажлын тайланд "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоо, түүний зорилго, зарчим, төрөлжсөн хэв шинжүүд" хэсгийг боловсруулах	60	10	70	70
3.	"Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга хэсэгт хөдөлмөр эрхлэлтийн тайлан бэлтгэх	60	10	70	70
4.	Үндэсний статистикийн хорооноос "Зохистой хөдөлмөрийн статистик үзүүлэлтүүдийг тооцох гарын авлага"-д санал боловсруулах	60	10	70	70
5.	Нийгмийн хамгааллын үндэсний тогтолцооны үзэл баримтлалыг танилцуулах хэлэлцүүлэг зохион байгуулах	60	10	70	70
6.	ХЭДТХ-ийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллах	60	10	70	70
7.	ГБХНХ-ын салбарын үндсэн үзүүлэлтэд Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийг 2020-2024 он, 2025 оны I улирлын байдлаар бэлтгэх	60	10	70	70
Дундаж оноо:				67.08	67.08

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Монгол бичгийн /8 удаагийн/ сургалтад хамрагдсан.			
Дундаж оноо			14	14

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй		
2.	Дүн шинжилгээ хийх		
3.	Асуудал шийдвэрлэх		
4.	Хариуцлагатай байдал		
5.	Ажлын цаг ашиглалт		
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо		6.5	6.5

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	
2.	Багаар ажиллах	
3.	Харилцаа	
Дундаж оноо		7.5

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо)
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо)
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо)
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо)
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(... оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		95.1

Үнэлгээ өгсөн:

НБТГ-ын дарга

(албан тушаал)

Үнэлгээ өгсөн:



(гарын үсэг)

Нэгжийн дарга

/Б.Алимаа/

(албан хаагчийн нэр)

Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:

НБТГ-ын ахлах мэргэжилтэн

(албан тушаал)

..... (огноо)

Төрийн жинхэнэ албан хаагч:



(гарын үсэг)

/Н.Золжаргал/

(албан хаагчийн нэр)

2025.06.13 (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

(албан тушаал)

(гарын үсэг)



Б.Нувшинжарал
(албан хаагчийн нэр)

2025.06.10 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

.....

(албан тушаал)



(гарын үсэг)

/О.Очирагч/

(албан хаагчийн нэр)


2025.06.10 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

.....

(албан тушаал)

Төсвийн шууд захирагч



(гарын үсэг)

/Т.Монхзуу/

(албан хаагчийн нэр)

2025.06.20 (огноо)

